



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 09 сарын 19 өдөр

Дугаар 38

Улаанбаатар хот

Дуудлагын худалдааг
дахин зохион байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.2, 4.3, 4.4 дахь заалт, "Мэдээ, тайлангийн маягт батлах тухай" 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Булган аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, нийт 14,000,000.00 (арван дөрвөн сая) төгрөгийн балансын үнэ бүхий автомашины нээлттэй дуудлагын худалдааг дахин зохион байгуулахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтаар шинэчлэн тогтоосугай.

2. Стандарт, хэмжил зүйн газрын Тамгын газрын дарга Б.Эрдэнэзул, Булган аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дарга Ц.Бүрэнтуяа нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Ажлын хэсэг байгуулж хавсралтад заасан автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах ажлыг Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2 Дуудлагын худалдаанаас олох орлогыг дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4.Арга хэмжээний биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт болон хөрөнгийн үнийг улсын төсөвт төвлөрүүлсэн баримтын хамт 2019 оны 04 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

А.АРИУНБОЛД

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ЭРДЭНЭБАЯР

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 09 дүгээр сарын 18 ны өдрийн
688 дугаар тогтоолын хавсралт

БУЛГАН АЙМГИЙН СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТСИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ДАХИН ХУДАЛДАХ АВТОМАШИН

Д/д	Автомашинны марк, улсын дугаар, зориулалт, арлын дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Нийт гүйлт (км)	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг	Сэргээн босголтын зардал	ТӨБЗ-ЫН 2018 оны	Шинэчлэн
								561 дугаар тогтоолоор тогтоосон доод үнэ	тогтоосон худалдах доод үнэ
(төгрөг)									
1	Ниссан Х трейл, 03-30 БУА, суудлын автомашин, арлын дугаар NT3005855	2002/2011	81,500	14,000,000.00	14,000,000.00	-	2,568,600.00	4,000,000.00	2,500,000.00
				14,000,000.00	14,000,000.00	-	2,568,600.00	4,000,000.00	2,500,000.00
НИЙТ ДҮН									
				(арван дөрвөн сая)	(арван дөрвөн сая)	-	(хоёр сая таван зуун жаран найман мянга зургаан зуу)	(дөрвөн сая)	(хоёр сая таван зуун мянган)